



“ЛэндМН ББСБ” ХК-ийн
**2025 оны III улирлын санхүү,
үйл ажиллагааны тайлан**

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ



Lenddy

Бизнес эрхлэгч таны
БОРЛУУЛАЛТАА ӨСГӨХ
ШИНЭ БОЛОМЖ

Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2025 оны III улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

Үйл ажиллагааны хураангуй

01

Санхүүгийн тайлан

02

Компанийн засаглал

03

БОРЛУУЛАЛТ НЭМЭГДҮҮЛЭХ ШИНЭ БОЛОМЖ – LENDDY

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН” гэх) нь технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн үйлчилгээг харилцагчдадаа илүү хялбар, хурдан, хүртээмжтэй хүргэх зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд 2024 онд Монголд анх удаа барьцаагүй, бүрэн дижитал бизнесийн зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн билээ. 2025 оны III улирлын байдлаар нийтдээ 250 мянга гаруй зээлийн тооцоолол хийгдэж, 100 тэрбум гаруй төгрөгийн зээлийг бизнес эрхлэгч нартаа олгосон байна.

LendDy үйлчилгээ маань зах зээлд нэвтрээд ердөө 4 сарын хугацаанд мянга мянган бизнес эрхлэгчдэд шинэ # БОЛОМЖИЙГ_БҮТЭЭЖ өглөө.

ЛэндМН нь энэ оны тавдугаар сард харилцагчдынхаа санал, хүсэлт дээр тулгуурлан LendDy хэмээх худалдан авалтын шинэ бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлсэн билээ. Энэхүү үйлчилгээгээр дамжуулан бизнес эрхлэгч хувь хүн, аж ахуй нэгжүүдэд өөрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ дараа төлбөрт хүүгүй нөхцөлөөр худалдан борлуулаад, борлуулалтын орлогоо өдөртөө авах боломжийг санал болгож буй юм. LendDy үйлчилгээгээр бид жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн тогтвортой байдлыг дэмжих санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна бизнесийн үйл ажиллагааг нь тэлэх цогц дэмжлэгийг үзүүлж, ЛэндМН-ийн 200 мянга гаруй харилцагчдаараа дамжуулан борлуулалтыг нь бодитоор дэмжихийг зорин ажиллаж байна.

LendDy үйлчилгээний давуу тал:

5 минутын дотор LendDy-тэй бизнес эрхлэгч болох боломж

- Оочир дараалал хүлээн уулзалтын цаг товлож, цаг алдахгүйгээр өөрийн ашиглаж буй гар утаснаасаа LendMN аппликейшнийг ашиглан бүртгэлээ хийлгэх боломжтой.
- Бидний санал болгож буй технологийн шийдлийг ашиглан ямар нэгэн баримт бичгийг цаасан хэлбэрээр бэлдэх шаардлагагүй.
- Бүртгэлээ хийсэн даруйд үйлчилгээний эрх нээгдэж, үйлчлүүлэгчдэдээ LendDy төлбөрийн шийдлийг санал болгосноор борлуулалтаа бодитоор өсгөх боломжтой.

Борлуулалтын орлогоо өдөртөө авах хурдан бөгөөд үр ашигтай шийдэл

- LendDy үйлчилгээг ашиглан борлуулалтын орлогоо цаг хугацаа алдахгүйгээр авах боломжтой.

ЛэндМН нь цаашид ч бизнес эрхлэгч завгүй, хөдөлмөрч харилцагч нартаа тулгарч буй асуудлуудыг технологийг ашиглан илүү хялбараар шийдэх, бизнесийн үйл ажиллагаанд нь бодит дэмжлэг үзүүлэх шинэ боломжуудыг судлан нэвтрүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Монголын финтек салбарын түүхэн амжилт




Монголын анхны финтек компани “ЛэндМН ББСБ” ХК-ийн толгой компани АНД Глобал Пти.Лтд. нь IFC East Asia Pacific, AEON Financial Service, Marubeni, SBI Holdings зэрэг дэлхийн нэр хүндтэй хөрөнгө оруулагчдаас 21.4 сая ам.долларын Series B хөрөнгө оруулалтыг амжилттай татлаа.

Энэхүү хөрөнгө оруулалт нь Зүүн Өмнөд Азийн бичил, жижиг, дунд бизнесүүдэд чиглэсэн хиймэл оюун ухаанд суурилсан финтек шийдлүүдийг хөгжүүлэх стратегийн чухал алхам боллоо.

Түншлэлийн хүрээнд LendMN аппликейшнээр дамжуулан санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, засаглалын ил тод байдал, эрсдэлийн удирдлага, хариуцлагатай зээл олголтын олон улсын стандартыг нэвтрүүлэх юм.

Энэхүү түншлэл нь гарааны бизнесүүд, эмэгтэйчүүд, залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох, санхүүгийн хүртээмжийг сайжруулахад чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Эмэгтэйчүүдийн хөгжил ба манлайллыг дэмжих санаачилга



“ЛэндМН ББСБ” ХК нь нийгмийн хариуцлага болон “Хүн төвтэй хөгжил” зарчмын хүрээнд эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, манлайллыг бүх салбарт дэмжин ажилладаг. Бид эмэгтэйчүүдийн хүч чадал, хүсэл тэмүүлэл, манлайлал, нийгэмд оруулах хувь нэмрийг санхүүгийн шийдлээр дэмжихийг зорьдог.

Иймд бид 2025 оны Эмэгтэй Үндэсний Дээд Лигийн шинэ улирлын тоглолтод “Алтан Од” багийн ивээн тэтгэгчээр ажиллаж, эмэгтэй тамирчдын ур чадвар, тэмүүлэл, хамтын ажиллагааг урамшуулан дэмжлээ.

Энэхүү ивээн тэтгэгчийн хамтын ажиллагаа нь ЛэндМН-ийн “Хариуцлагатай санхүүгийн байгууллага байх” стратегийн хүрээнд нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, спорт

болон нийгмийн манлайллыг дэмжих урт хугацааны зорилттой уялдаж буй юм.

Бид цаашид ч эмэгтэйчүүдийн хөгжлийг эдийн засаг, бизнес, спорт, урлаг зэрэг бүхий л салбарт тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн шийдлээр дэмжихийг эрмэлзэн ажиллах болно.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд /Өссөн дүнгээр/:



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Өссөн дүнгээр, тэрбум төгрөг/	2023.III	2024.III	2025.III
Нийт орлого	33.2	64.1	97.2
Хүүгийн зардал	(6.8)	(14.9)	(24.8)
Цэвэр орлого	26.4	49.2	72.4
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(3.1)	(3.4)	(3.6)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(2.3)	(3.5)	(17.1)
Үйл ажиллагааны цэвэр орлого	21.0	42.3	51.6
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(4.5)	(6.3)	(10.4)
Татварын өмнөх ашиг	16.5	36.0	41.2
Татварын зардал	(3.5)	(8.5)	(9.2)
Цэвэр ашиг	13.0	27.5	32.0

Санхүү байдлын хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2023.III	2024.III	2025.III
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.8	16.2	6.9
Зээлийн багц (цэвэр)	94.7	200.8	276.5
Бусад хөрөнгө	3.3	9.5	19.5
Үндсэн хөрөнгө	0.7	1.3	4.5
Биет бус хөрөнгө	0.4	0.3	0.7
Нийт хөрөнгө	103.9	228.2	308.1

Өр төлбөр болон эздийн өмч /Тэрбум төгрөг/			
Өр төлбөр	68.0	163.9	214.2
Эх үүсвэр	57.4	140.8	185.1
Бусад өглөг	7.8	20.3	26.3
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Эздийн өмчийн дүн	35.9	64.3	93.9
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	27.4	55.8	85.4
Нийт өр төлбөр болон эздийн өмч	103.9	228.2	308.1

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2025 оны III улиралд 1 удаа ээлжит хурал, 2 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 7 тогтоол гаргав. Эдгээр шийдвэрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг шинээр томилох, 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох болон Өрийн хэрэгсэл нийтэд санал болгон гаргах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэн ажилласан байна.

ЛэндМН нь ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлсэн болно.

Компанийн засаглалын кодексын хэрэгжилт

ЛэндМН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг Санхүүгийн зохицуулах хорооны үнэлгээний хүрээнд 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 93%-тай хэрэгжүүлэн ажиллаж, компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn